

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2018 ОНЫ 03 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.04.05

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 03 дугаар сард 1 удаа хуралдаж 11 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын IX хуралдааныг 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хуралдуулж аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайлан, Аймгийн 2018 оны төсөвт урьд оны үлдэгдэл нэмж батлах тухай, Зарим газар нутгийг аймгийн тусгай хэрэгцээнд авах тухай, Малын зарим халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний төлбөрийг аж ахуйн нэгж, малчид, иргэдээс гаргуулах тухай тогтоолын төсөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны ажлын тайланг тус тус хэлэлцэхээр тогтлоо.

-”Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөрийг баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг жил бүр аймгийн төсөвт тусган шийдвэрлүүлж байхыг даалгалаа.

-Сум дундын ойн ангиудын харьяалах сум, хамаарах нутаг дэвсгэр, хариуцах талбайн хэмжээг хэлэлцэн баталж, тогтоол гарсантай холбогдуулан “Сум дундын ойн анги байгуулах тухай” 2012 оны 126 тоот тогтоолыг хүчингүй болголоо.

Сум, байгууллагын хэмжээнд тэгш ой тэмдэглэх журмын дагуу Сэлэнгэ аймагт Эрчим хүчний байгууллага үүсч хөгжсөний 60 жил, Орхон сумын 12 дугаар цэцэрлэгийн 60 жил, Сант сумын Цагаантолгойн сангийн аж ахуйн 90 жилийн ойг тэмдэглэх хүсэлт ирснийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Төрийн захиргаа, эрүүл мэнд, хууль хяналт, хөдөө аж ахуй, газар тариалан, эрчим хүч, соёл урлагийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид, 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж 6-аас доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлсэн 16 эхийг Алдарт эхийн I одонгоор, 4-5 хүүхэд төрүүлж 4-өөс доошгүй хүүхдийг өөрийн асрамжаар өсгөн хүмүүжүүлсэн 295 эхийг Алдарт эхийн II одонгоор тус тус шагнуулахаар тус тус уламжиллаа.

Дэлхийн эмч нарын баярын тохиолдуулан эрүүл мэндийн салбарт олон жил идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гарган аймаг, орон нутгийнхаа хөгжил, дэвшилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж аймгийн хэнцгдсэн эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Д.Болормаа, Чанарын албаны дарга Ц.Сонинбаяр нарыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

Мөн Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг, аймгийн ИТХ-ын ажлын алба хамтран “Монгол улс дахь төлөөлийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд зориулсан Манлайллын сургалтыг энэ сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга сумдын ИТХ-ын дарга нарыг хүлээн авч уулзан сум орон нутгийнх нь хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тайлан, хүсэлтийг сонсож аймгаас хийж хэрэгжүүлж байгаа ажлыг тангилцуулан цаашид анхаарч ажиллах асуудлуудаар чиглэл өглөө.

2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

2018 оны 3-р сарын 21-ний байдлаар аймгийн дүнгээр нийт төллөх эх малын 19,5 хувь нь буюу 141,5 мянган эх мал төллөж, 142,0 мянган төл хүлээн авч, төл бойжилт 99,04 хувьтай байна.

Энэ хавар нийтдээ 178,8 мянган га-д тариалалт хийхээс үр тариа 142,8 мянган га-д, төмс 2,5 мянган га-д, хүнсний ногоо 2,3 мянган га-д тариалахаар төлөвлөж, тариаланчдын зөвлөгөөнөө энэ 4-р сард зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.

Улсын хэмжээнд хийгдэж буй аж үйлдвэрийн нэгдсэн тооллогын ажлыг хэсгийг аймаг, суманд томилон ажиллуулж, Үндэсний хөгжлийн газрын цахим бүртгэлийн системд бүртгэх ажлыг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 50 аж ахуйн нэгжийн мэдээллийг оруулах ажил хийгдээд байна.

Аймгийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй иргэдээс гаргасан санал хүсэлтийг харгалзан үзүүлж буй үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж Газрын болон улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх нөхцөл боломжийг хангаж, шилэн кабелийг нэмэлтээр татаж, офлайн горимын хандалттай тусгай систем бүхий сүлжээний өргөтгөлийг хийлээ.

Мөн аймгийн төрийн албан хаагчдын сурч, хөгжих, ажиллах нөхцөлийг сайжруулах, үйл ажиллагаа, санал, санаачлагыг дэмжих, тэдний өрхийн амьжиргааг дээшлүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, ажиллах урам зориг, хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл-Нийгмийн баталгаа” хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл хамтран Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг сурталчлах, тайлбарлан таниулах, сургалт зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах, иргэд, үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор “Хэрэглэгчээ сонсьё” өдөрлөгийн арга хэмжээг Сэлэнгэ Олон Улсын Худалдааны Төвд амжилттай зохион байгуулагдаж, “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ, “Урсгал-Ус” ХХК, “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч нар оролцож, иргэдийн сонирхсон асуултад хариулан, шинэ мэдлэг мэдээллийг олголоо. Энэ үеэр өдөрлөгт оролцсон байгууллага тус бүр гарын авлага тарааж, нийт 143 иргэнд үйлчилгээ үзүүлээ. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төсөлд иргэд байгууллагуудаас санал авч нэгтгэн Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт хүргүүлээ.

Зэвсэгт хүчний 97 жилийн ой “Монгол Цэргийн өдөр”-ийг тусгай төлөвлөгөөний дагуу аймагт үйл ажиллагаа явуулж буй тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын албан хаагчдын дунд цэрэг-спортын олон төрөлт тэмцээнийг 2018 оны 03 дугаар сарын 07-15-ны өдүүдэд зохион байгууллаа. Нийт зохион байгуулсан цэрэг-спортын олон төрөлт тэмцээний нэгдсэн дүнгээр Хилийн 0101 дүгээр анги Тэргүүн байр эзэлж Сүхбаатар цэргийн хотхоны 2018 оны шилдэг байгууллага “Өргөмжлөл”, алтан медаль, Шилжин явах цомын эзэн болсон бол дэд байранд шалгарсан Хилийн 0243 дугаар, гутгаар байр эзэлсэн аймгийн Онцгой байдлын газрын хамт олныг мөнгөн, хүрэл медаль өргөмжлөлөөр шагнаж урамшууллаа.

Аймгийн төв Сүхбаатар хотноо Ази тивийн хошой аварга Монголын боксын спортын ууган гавьяат тамирчин Хайдавын Алтанхуягийн нэрэмжит залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээн анх удаагаа амжилттай зохион байгуулагдаж багийн дүнгээр 1-р байр Алдар спорт хороо, 2-р байр Улаан ирвэс клуб, 3-р байр Эрдэнэт бокс клубууд удааллаа.

Идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнийг зохион байгуулж, 41 багийн 360 гаруй тамирчдын хурд хүч авхаалж самбаагаа сорин

цэцэрлэг хамрагдаж Ерөнхий боловсролын сургуулийн 732 багш, ажилчид, 6055 сурагчид, цэцэрлэгийн 368 багш, ажилчид 2972 хүүхдүүд нийт 1100 багш, ажилчид, 9027 сурагч, хүүхэд хамрагдаж болзошгүй гамшгийн үед өөрийнхөө аюулгүй байдлаа хэрхэн хангах, аюулгүй цэгт ямар дарааллыг баримтлан шилжин байрших талаар мэдлэгтэй боллоо.

Онцгой байдлын газрын даргын 2018 оны “Хяналт, шалгалт, сургалт зохион байгуулах” тухай А/08 дугаар тушаалын дагуу Орхон суманд гамшгаас хамгаалах хяналт, шалгалт сургалтын арга хэмжээг 03 дугаар сарын 22-ны өдөр зохион явууллаа. Уг арга хэмжээнд сумын Онцгой комисс, мэргэжлийн ангийн гишүүдийг зарлан мэдээллийн дохиогоор цуглуулан багаж техник хэрэгсэл, хүн нэг бүрийн үүргэвчний бэлэн байдлыг үзэж шалган заавар зөвлөгөө өгч Онцгой комисс, мэргэжлийн ангийн 66 гишүүнд бэлэн байдлын сургалтын багцаас “ой, хээрийн түймэр”, “Мал амьтны гоц халдварт өвчин”, мэргэжлийн ангийн дүрэм болон гамшгийн менежмент сэдвүүдээр танхимын сургалт зохион байгуулж сургалтын үеэр оролцогчдыг бүлгүүдэд хувиарлан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээний талаар ажиллуулан илтгэлийг сонсож үнэлэлт дүгнэлт өгч, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 20 багш ажилтанд аюулгүй сургууль сэдэвт сургалтыг тус тус зохион явууллаа.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд Ерөө, Сүхбаатар, Сайхан, Мандал, Баянгол, Шаамар сумдын 22 аж ахуйн нэгж, иргэний 12 хүнсний дэлгүүр, 1 кафе, 2 зоогийн газар, 1 биллъярдын үйлчилгээний газар, 1 дэн буудал, 1 гэр буудал, 1 худалдааны агуулах, 2 минимаркет, 1 супермаркетэд тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгосон.

Сүхбаатар сумын 5-р багт байрлах “Сэ Тэ Би” ХХК-ний “Сэлэнгэ” нэрийн зөгийн балыг сайн дурын баталгаажуулалтанд хамруулан шинжээчийн дүгнэлт гаргаж, стандартын салбар сангаас 6 аж ахуйн нэгж, байгууллага иргэний 10 нэрийн 12 стандартын захиалгыг авч, 5 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд 8 нэрийн 9 стандартаар борлуулалт хийж, 1 аж ахуйн нэгж, байгууллага иргэнийг 2 нэрийн 3 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн.

Мөн Сүхбаатар суманд ажиллах худалдааны газруудын 44 жин, 2 туухайг ээлжит баталгаажуулалтанд хамруулж, Сүхбаатар сумын 4 барьцаалан зээлдүүлэх газрын 7 жинг баталгаажуулан 9 тухайнд шалгалт тохируулга хийлээ.

Цахилгааны хэмжлийн төрлөөр 5163 нэг фазын электрон тоолуур баталгаажуулах ажлыг Дархан уул аймаг дахь ДСЦТС ХХК-ний хэмжилзүйн лабораторитой хамтран хийсэн.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг сумд, төсөвт байгууллагуудаас хугацаанд нь зохих заавар журмын дагуу хянан баталгаажуулж, хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны зарцуулалтын тайланг Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газарт, аж ахуйн нэгж, байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэл мэдээг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт тус тус хүргүүллээ.

Сумдын Санхүүгийн албанд шинээр томилогдсон төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдийг дадлагажуулах дадлагын удирдамжийг гаргаж, Баянгол, Шаамар, Хүдэр сум, Дулаанхаан тосгоны төрийн сангийн мэргэжилтнүүдийг 3 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст дадлагажуулан шалгалт авч, цаашид анхаарч ажиллах талаар чиглэл өглөө.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		12.504.984.6	14.953.648.4	119.6
1.1	Орон нутгийн төсвийн орлого	2.173.048.4	2.537.054.4	116.8
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	1.593.950.9	1.879.602.0	117.9
	Сумдын төсвийн орлого	579.097.5	657.452.4	113.5
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1.350.000.0	1.350.000.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	7.815.788.7	7.815.788.7	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	351.524.7	351.524.7	100.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	736.151.6	2.761.970.3	375.2
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	78.471.2	137.310.3	175.0
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		12.504.984.6	9.754.571.5	78.0
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	12.504.984.6	9.754.571.5	78.0
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	1.931.969.3	1.200.169.6	62.1
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	194.525.0	4.829.3	-
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	2.547.910.0	1.819.530.3	71.4
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	-	86.200.0	-
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	-	-	-
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	213.582.3	-	-
	Халамжийн сан	1.505.904.0	1.193.198.7	79.2
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	768.423.7	480.131.6	62.5
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	60.000.0	60.000.0	100.0
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	7.256.458.2	6.265.686.3	86.3
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	574.122.1	464.356.0	80.9
	3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		9.084.436.6	9.084.436.6
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	917.123.2	917.123.2	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	183.410.1	183.410.1	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	21.888.2	21.888.2	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	161.521.9	161.521.9	100.0
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	168.114.6	168.114.6	100.0
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	168.114.6	168.114.6	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	-	-	-
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	7.247.779.6	7.247.779.6	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	568.009.1	568.009.1	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	7.815.788.7	7.815.788.7	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	3.678.549.9	3.678.549.9	100.0

	- Хүүхдийн цэцэрлэг	2.046.019.9	0.46.019.9	100.0
	- Соёлын байгууллага	591.286.4	591.286.4	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	286.082.6	286.082.6	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	1.067.458.7	1.067.458.7	100.0
	- Газрын кадастрын байгууллага	77.401.0	77.401.0	100.0
	- Хүүхдийн байгууллага	68.990.2	68.990.2	100.0
	4. Тусгай сангуудын зарлага	362.258.1	15.000.0	4.1
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	362.258.1	15.000.0	4.1

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018 II- сар	2018 III- сар	<u>2018- III</u> <u>2018- II</u> /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 400	1 100	78.6
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	100.0
	Нарийн боов /кг/	2 400	2 500	104.2
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 300	2 200	95.7
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	5 000	5 500	110.0
	Үхрийн мах /кг/	5 600	7000	125.0
	Адууны мах /кг/	5 500	5 000	90.9
	Ямааны мах /кг/	4 600	4 800	104.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	3 500	116.7
	Хиам /чанасан, кг/	11 000	10 000	90.9
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 400	1 800	128.6
	Сүү / савласан, л/	2 500	2 600	104.0
	Тараг /задгай, л/	1 800	2 000	111.1
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	12 000	92.3
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 000	4 500	112.5
	Өндөг /ш/	320	350	109.4
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 700	3 800	102.7
	Өөхөн тос /кг/	2000	1 500	75.0
	Шар тос /кг/	12500	15000	120.0
	Масло /задгай, кг/	4800	4500	93.8
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 000	1 200	120.0
	Лууван /кг/	1 400	1 200	85.7
	Манжин /кг/	1 300	1 500	115.4
	Байцаа /кг/	1 500	1 500	100.0
	Сонгино /кг/	1 500	1 500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3300	3 500	106.1
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 600	2 300	88.5
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 580	1 590	100.6

Бензин А - 92	1 650	1 735	105.2
Дизелийн түлш	1 820	2025	111.3

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

2018 онд зохион байгуулах эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөө, 2018 онд хууль хяналтын байгууллагуудын хамтран ажиллах хуваарь, төлөвлөгөөг тус тус аймгийн Засаг даргын захирамжаар батлан сум, агентлаг, холбогдох газруудад хүргүүлжээ.

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Захиргааны ерөнхий хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, “Зөрчлийн тухай” хууль, “Шилэн дансны тухай” хууль, Газрын багц хуулиуд, Нийгмийн даатгалын багц хуулиуд, “Хүүхэд хамгааллын тухай” хууль зэрэг сэдвүүдээр сургалт, сурталчилгааны ажлуудыг Алтанбулаг, Баянгол, Ерөө, Мандал, Хүдэр, Зүүнбүрэн, Жавхлан, Орхонтуул, Хушаат, Цагааннуур сумд болон зохион байгуулж нийт 1546 иргэн хамрагдсан байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ээлжит хурлыг 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж 2017 оны ажлын мэдээ, 2018 оны төлөвлөгөө болон бусад асуудлыг хэлэлцлээ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бэлтгэж буй хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, сурталчилгааны www.e-khutuch.mn цахим хуудсанд байршуулах аймгийн төрийн болон төрийн үйлчилгээний байгууллагуудын мэдээллийг нэгтгэн Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлсэн.

2018 оны эхний 3-р сарын 01-ний байдлаар гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 139, гэмт хэрэг 108 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гомдол мэдээлэл 34.7%-иар, гэмт хэрэг нь 8.5%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 03 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 257, бусад үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ 78, лавлагаа тус тус 2 олгосон.

03 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:

- ✓ Төрсний бүртгэл – 188 /эрэгтэй-77, эмэгтэй-111/
- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 50
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 16
- ✓ Үрчлэлт- 2
- ✓ Эцэг тогтоолт – 6
- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 11
- ✓ Нас баралт – 56
- ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 782
- ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 283
- ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 78
- ✓ Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 421
- ✓ Гадаад паспорт олголт – 115
- ✓ Аймаг хот руу бүр мөсөн шилжин явсан – 144
- ✓ Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 277
- ✓ Хот доторх шилжилт хөдөлгөөн – 656 тус тус бүртгэгдсэн байна.

Архивын чиглэлээр:

2018 онд сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх төлөвлөгөө, хуваарийн дагуу Зүүнбүрэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 1986-2012 оны 8 хадгаламжийн нэгж, Соёлын төвийн 2006-2012 оны 12 хадгаламжийн нэгж, Эрүүл мэндийн төвийн 1987-2012 оны 28 хадгаламжийн нэгж, Ерөнхий боловсролын сургуулийн 2005-2012 оны 11 хадгаламжийн нэгжийг тус тус хүлээн авч акт, бүртгэл үйлдэн төр, төсвийн

байгууллагуудын удирдлагын нийт 99 хадгаламжийн нэгжийг скайнердаж мастер хувь үүсгэсэн.

Иргэд, албан байгууллагаас ирсэн хүсэлтийн дагуу архивын хуулбар цахимаар 56, цаасан суурьтай баримтнаас 26, мастер хувиас 131, тодорхойлолт 36, эхийн одонгийн лавлагаа 2, цалингийн тодорхойлолт 2 тус тус гаргаж үйлчилсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

Хараа бүсийн сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн байгууллагуудад зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, анги дүүргэлт, багшийн хүрэлцээ хангамж, сонгон гүнзгийрүүлж судлах хичээлийн төлөвлөлт, хэрэгжилт, сургалтын орчны тохижилт, засвар үйлчилгээ, эрүүл ахуй, хүүхэд бүрийг хөгжүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажил, түүний үр дүн, сурагчийн дүрэмт хувцас, сурах бичгээр хангагдсан байдал, хүрэлцээ хангамж, сурах бичиг худалдан авалт, номын сан, дотуур байр, сургууль, цэцэрлэгийн гал тогоо, үдийн цай, хөрөнгө оруулалт, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг тусгай удирдамжийн дагуу газар дээр нь үзэж танилцаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч нийтдээ 65 цагийн хичээл, үйл ажиллагааг ажиглаж, 250 гаруй багш, ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, 264 багшийг судлагдахууны болон заах арга зүй, өсвөр насны хүүхдийн хөгжил, төлөвшил, тогтвортой хөгжлийн боловсрол, гарын доорх материалыг сургалтад ашиглах арга зүйн талаар өртөөчилсөн сургалтад хамрууллаа.

МУИС-иас төвийн болон хангайн бүсийн аймгуудтай уулзалт хийх, хамтын ажиллагааны санал солилцох, сургалт зохион байгуулах ажлыг 2018.02.27-нд хэрэгжүүлж, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулиудын 350 гаруй сурагчийг оролцууллаа.

“Боловсролын салбарт ил тод байдал, ёс зүйг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ерөнхий боловсролын сургуулиудад болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад зохион байгуулах тухай” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, багш нарын төлөөлөл 40, цэцэрлэгийн 10, Боловсрол соёл урлагийн газрын мэргэжилтэн 10, МСҮТ-ийн захирал, багш нарын төлөөлөл 60 гаруй хүнийг оролцуулсан.

“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-ын дагуу 5, 9, 12 дугаар ангийн сурагчдаас авах боловсролын чанарын үнэлгээний судалгааны шалгалтыг зохион байгуулж Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургууль, Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас авч, Боловсролын үнэлгээний төвд хүргүүлсэн.

Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд Дэлхийн банк, БСШУСЯ хамтран хэрэгжүүлж байгаа “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн 3 дугаар шатны хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Мандал сумын 1, 2, 3, Хушаат, Орхон, Сант, Баруунбүрэн, Сайхан, Номгон, Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулиуд дээр ажиллаж, төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар эцэг эхчүүдтэй бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан.

2.Эрүүл мэндийн талаар:

Халдварт болон Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг Сайхан, Орхон суманд зохион байгуулж, 15-аас дээш насны иргэдийг хамрууллаа. Үзлэг оношлогоог 15 төрлийн нарийн мэргэжлийн эмч, 11 төрлийн оношлогоо шинжилгээ, хүүхэд өсвөр үеийн эрүүл мэндийг хамгаалах сэтгэцийн зөвөлгөө өгөх баг ажиллалаа. Хүнд хэвтрийн өвчтэй ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнд гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Сайхан, Орхон сумын нийт хамрагдвал

зохих хүн амын 70 гаруй хувийг хамруулснаар иргэдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн санг үүсгэсэн.

“Манлайгчдыг хайж байна, Та ч байж болно, Түүхийг бүтээ” уриан дор дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдрийг угтан бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд хүн амын дунд сүрьеэ өвчний тухай зөв ойлголт, эрт илрүүлгийн ач холбогдол, зөвхөн эмийн эмчилгээнд эдгэрдэг, хэрхэн урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, витаминжуулах аян, оройн үдэшлэг, АХА, ил захидал, спорт, сүрьеэгийн хэлэлцүүлэг, эмзэг бүлгийн сүрьеэгээр өвдсөн хүмүүст хүнсний дэмжлэг зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулж нийт 6000 гаруй иргэд хамрагдсан.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2018 оны 02-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 888 байсан бол 128 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 27 ажлын байранд 11 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 94 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 911 болсон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хооронд байгуулсан “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 14 дэх удаагийн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийг 3-р сарын 5, 6, 7-нд зохион байгуулж, 20 эмэгтэй, 124 эрэгтэй нийт 144 иргэний бүртгэлийг хийсэн.

Сумдын Хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарыг чадавхижуулах сургалт, семинарыг зохион байгуулсан.

Нийгмийн халамжийн сангаас 03 дугаар сарын байдлаар 30,927 иргэнд 3,182,630.140 төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгоод байна.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Аймгийн Засаг даргын 2018 оны А/63 тоот захирамжаар аймгийн “Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл” байгуулагдаж, үйл ажиллагааны чиглэл, орон нутгийн залуучуудын оролцоог идэвхжүүлэх зорилгоор анхны “Кофет уулзалт”-ыг зохион байгууллаа. Уулзалтанд аймгийн “Залуу эмч нарын холбоо”, “Залуу багш нарын холбоо”, Сүхбаатар сумын НАМЗХ-ын тэргүүлэгч болон гишүүд, бусад залуучуудын төлөөлөл оролцож хамтран ажиллах чиглэл, нөөц боломжоо судлан, чөлөөт ярилцлагыг өрнүүллээ.

Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих ажлын хүрээнд 17 суманд 3 чиглэлийн дагуу хийж, Ерөнхий боловсролын сурагчдын дунд цахим мэдээллийн сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, зохистой хэрэглээг бий болох сургалтыг зохион байгуулж сургалтанд 1126 хүүхэд хамрагдсан. Мөн “Бүтээе- Нэгдье- Харилцан хүндэлье”, “Эерэг Интернет танаас эхэлнэ” урианд нэгдсэн Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, багш нарт “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сургалтыг зохион байгуулж нийт 120 багшийг хамрууллаа.

Нэг хүүхэд-Нэг байгууллага” аяны хүрээнд эрсдэлт бүлгийн 1-2 хүүхдийг сонгон авч туслан дэмжих, гэр бүлд нь эргэн нэгтгэх, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор 17 сум, 6 тосгоны төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд 3 сарын хугацаатай аяныг эхлүүлээд байна.

“Лидер сурагч” академитай хамтран “Оюуны давалгаа –IY” аймгийн уран илтгэлийн тэмцээнийг 4 дэх жилдээ зохион байгуулж нийт 10 сумдын 14 сургуулийн 30 сурагч оролцсон. Мөн “Би эстрадын дуучин-2018” аймгийн уралдааныг зохион байгуулж уралдаанд нийт 9 сум, 6 тосгоны 170 гаруй хүүхэд хамрагдлаа.

5.Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын байцаагч нарын нэгдсэн сургалт зөвөлгөөнийг зохион байгуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын зөвлөх, мэргэжилтнүүд оролцож хууль тогтмоомжийн өөрчлөлтүүд, түүнийг хэрэгжүүлэх заавар журмуудаар мэдээлэл өгч, хэлтсийн 2017 үйл ажиллагааны тайлан, байцаагч нарын үр дүнгийн үнэлгээг хэлэлцэж, 2018 оны үр дүнгийн гэрээ болон хамтран ажиллах болон хариуцлагын гэрээг байгууллаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 4,3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 03-р сарын 23-ны байдлаар өссөн дүнгээр 3,7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 86,2 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16051 тэтгэвэр авагчдад 9897.81 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 1027 хүнд 405.29 сая төгрөгийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, Жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 234 хүнд 195.08 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 71 хүнд 120.82 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Аймгийн хэмжээнд 2018 онд тэтгэвэр тогтоолгох малчин даатгуулагчийн нийт тоо 479 байна. Үүнээс тэтгэвэр тогтоолгох баримт бичиг нь бүрэн малчин даатгуулагч 19, тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэл дутуу малчны тоо 357 байна. 2018 оны 03 сарын 23-ны байдлаар 5 малчин-даатгуулагч тэтгэвэр тогтоолгосон байна. Малчин даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох журамтай холбогдуулан бүх сумдын мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын баримт буюу 'А' дансны судалгааг аймгийн хэмжээнд сум тус бүрээр нь хэдээс хэдэн оны баримт аймаг, сумын архивт хадгалагдаж байгаа талаар судалгааг гарган ажиллалаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2018 оны 03 сард нийт 3 удаа хурлыг зохион байгуулж 219 хүнээс, 15 хүнийг цуцалж, 34 хүн шинээр тогтоолгож, 170 хүн актаа сунгуулсан.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

“Мах, сүүний анхдугаар аян”-ы хүрээнд зохион байгуулсан 2017 оны ажлын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, “Мах, сүүний анхдугаар аян”, “Сав баглаа боодол үндэсний хөтөлбөр”, “Сэлэнгийн брэнд” хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах 2018 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан батлууллаа.

Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгох мөнгөн урамшуулал олгох журмын дагуу аймгийн хэмжээнд 1205 малчны 22211 ширхэг бодын арьс, 112180 ширхэг богийн арьс нийлүүлсэн тухай анхан шатны материалыг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-ны Мал хамгаалах санд хүргүүлсэн.

Зүүнбүрэн, Сүхбаатар, Баянгол, Хушаат сумдаас ирүүлсэн мал, амьтны халдварт өвчний сэжиг бүхий дуудлага бүрт шуурхай зөвлөгөө, зөвлөмжийг өгч, Зүүнбүрэн суманд байрлах “Шимт бүрэн” ХХК-ний 13 үнээний цусанд ийлдэс судлалын шинжилгээг хийж халдваргүй болохыг тогтоон Улсын мал эмнэлэг ариун цэврийн лабораторид баталгаажуулан хариуг зохих газарт хүргүүлэн ажиллалаа. Мөн аймгийн төвийн худалдааны төв, нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж буй МАА-н гаралтай мах, махан бүтээгдэхүүний 5155 кг махны 87 дээж, 165 л сүүний 8 дээжинд ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олгосон.

"Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP, GHP) нэвтрүүлэх зөвлөмж" хичээл, үзүүлэн, аудио, видеог Мандал, Сүхбаатар, Алтанбулаг, Сайхан, Баянгол, Цагааннуур, Ерөө, Хүдэр, Түшиг сумдын ресторан, кафе, цайны газар, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, МСҮТ, дотуур байр, үйлдвэрийн болон албан байгууллага, хорих анги, сувилал, зочид буудал, амралтын газруудын дэргэдэх хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулан танхимын

сургалтыг 9 удаа зохион байгуулж, 275 аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан 850 ширхэг гарын авлага материалаар хангаж, сурталчлан ажилласан.

Цэцэрлэг, сургуулийн хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор “Хүүхдийн болон эмчилгээний нарийн боовны түргэвчилсэн дадлага сургалт”-ыг аймгийн Тогоочдын холбоотой хамтран зохион байгуулж, Сүхбаатар, Хүдэр, Ерөө, Сант, Мандал сумдын 17 тогоочийг оролцуулан хүүхдийн хоолны онцлогт тохирсон гурилан бүтээгдэхүүн, шарах шүүгээнд жигнэж болгодог хөвсгөр пирошки, аарцтай торт, өндөг ороогүй печеньний төрлүүд, бүхэл үрийн талх, овъёостой бульчика, луувангийн талх зэрэг нарийн боовны технологи арга зүйд суралцсан.

Япон Улсын ЖАЙКА Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагаас хэрэгжүүлж буй “Зөгийн аж ахуйг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх” төсөл 2015 оноос эхлэн 3 жилийн хугацаанд үр дүнтэй хэрэгжиж дууссан бөгөөд ЖАЙКА ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага ХААИС, Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран сумдын Хөдөө аж ахуйн тасгийн малын эмч, мэргэжилтнүүд, хувийн мал эмнэлгийн эмч нийт 150 гаруй албан хаагч, зөгийн аж ахуй эрхлэгч иргэн аж ахуй, нэгжийн төлөөлөл 320 гаруй иргэн, нийт 470 гаруй хүнийг хамруулсан сургалтыг 3-р сарын 1, 2-ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулж, зөгийн аж ахуй эрхлэх шинэ технологийг эзэмшүүлэх зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохирсон зөгийн бал үйлдвэрлэх арга барилыг эзэмшүүлэх, технологийн заавар гаргах, голлох балт ургамлыг тогтоож зөгийн аж ахуйн календарь боловсруулах, орон нутагт зохицсон зөгийн аж ахуй эрхлэх технологийг тодорхойлох, технологийн зааварчилгааг хэрэгжүүлэх малын эмч, зөгийн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд хамтран ажиллах нөхцөл боломжийн талаар мэдээлэл өглөө.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжихээр 3,868,800.0 мянган төгрөгийн 13 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн бөгөөд 5 төсөл арга хэмжээний тендер одоогийн байдлаар зарлагдаж тендерийн материал цахимаар хүлээн авч байна. 1 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичиг боловсруулж байгаа ба 7 төсөл арга хэмжээний зураг төсөвзахиалагчаас ирүүлээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих 3,078,840.90 мянган төгрөгийн 27 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс нийт 426,057.70 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж, 1 төсөл арга хэмжээний тендерийн үнэлгээ хийгдэж байна. 335,057.70 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээний гэрээ байгуулагдсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих 1,734,800.80 мянган төгрөгийн 26 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс нийт 954,806.20 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж 4 төсөл арга хэмжээ үнэлгээ хийгдэх шатанд, 622,206.80 мянган төгрөгийн 7 төсөл арга хэмжээний гэрээ байгуулагдсан байна.

Байгаль хамгаалах сангийн зардлаар санхүүжигдэн хэрэгжих 564,900.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн. Нийт 378,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээний тендер зарлагдсан. 2 төсөл арга хэмжээ үнэлгээ хийгдэх шатанд, 3 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичиг боловсруулах шатандаа байна.

Долоо. Байгаль орчин, аялал жуулчлалын хүрээнд.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын “Нээлттэй өдөрлөг”-ийг 3 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд нийт сум, орон нутгийг хамруулан зохион байгуулж,

байгаль орчны багц хуулийн талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт сурталчилгаа хийж, цаг үеийн асуудлаар мэдээлэл өглөө.

Дэлхийн “Усны өдөр”-ийг “Байгальд ээлтэй усны шийдэл” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, Сүхбаатар сумын ЕБС-уудын ахлах ангийн сурагчдын дунд эссэ бичлэгийн уралдаан, АХА тэмцээн, байгаль орчны салбар байгууллагуудын дунд спортын 4 төрөлт тэмцээнийг тус тус зохион байгуулсан.

Орхонтуул, Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол, Түшиг, Сайхан сумын Засаг дарга нарт холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу ажлын хэсгийн дүгнэлт гаргуулаагүй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг явуулахгүй байх, хууль бус ашиглалтын үйл ажиллагааны эсрэг хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах тухай чиглэлийг өгч ажиллалаа.

Найм.Сум орон нутгийн талаар

Алтанбулаг сум:

“Малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-ыг 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, 80 гаруй малчин эмэгтэйчүүдийг төлөөлөгчөөр оролцуулан сум орон нутгаас дэвшүүлж байгаа бодлого зорилт, сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд, Эрүүл мэндийн төвийн эмэгтэйчүүдийн эмч зөвлөгөө мэдээллийг сонсож, санал хүсэлтээ сумын удирдлагад уламжилсан.

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар албан даалгавар, сумын Засаг даргын 2017 оны А/21 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг хүнсний аюулгүй байдал, архи, согтууруулах ундаа худалдан борлуулах журам, хог хаягдал, галын аюулгүй байдлыг хангуулах мөн гадна дотно тохижилт цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах зорилгоор 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд хоол, хүнсний чиглэлээр худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэд, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Баруунбүрэн сум:

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”, 2017 оны “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай” 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн А/78 дугаар захирамж, Сумын Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/25 дугаар захирамжийг үндэслэн сумын хэмжээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж Ерөнхий боловсролын сургуулийн нийт сурагчдад анги удирдсан багш нараар “Газар хөдлөлт”-ийн тухай сургалт зохион байгуулж, 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 16⁰⁰ цагт гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ЕБС-ийн 210 сурагч болон 35 багш, ажилчид, эцэг эхчүүдийг аюулгүйн цэгт нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулж “Газар хөдлөлтийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?”, “Газар хөдлөлтийн аюулаас сэргийлэх” сэдэвт видео бичлэг, шторкыг сурагчдад үзүүлээ. Мөн 25-р цэцэрлэгийн 12 багш, ажилчид 125 хүүхдэд газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж аюулгүйн цэгт нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас Бургалтайн 2 дугаар багийн Хар эрэг, Төмөртэй, Хувилгаан, Харанхуй ам, Шар хоолой, Хөх давааны ам, Цалгар, Бүдүүн хуст зэрэг газруудад өвөлждөг 30 гаруй өрх, малчдын хаваржилтын байдалтай

танилцан малчдын санаа бодлыг сонсохын зэрэгцээ зарим шаардлагатай үйлчилгээг хүргэж ажиллаад байна.

Сумын хэмжээнд 3-р сарын байдлаар том малын хорогдол 328 толгой байна. Мал төллөлтийн хувьд нийт 5875 толгой буюу төрлөөр нь авч үзвэл тугал 45, хурга 3270, ишиг 2560 толгой төллөсөн байна. Одоогоор төлийн хорогдол байхгүй байна.

Дархан-уул аймагт зохион байгуулагдсан “Тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, малчдад учирсан хохиролыг тооцох аргачлал”-ын хэлэлцүүлэгт сумын 2 малчин, 1 тариаланчийн төлөөлөлийг оролцууллаа.

Аймгийн МХГ-аас тус суманд групп шалгалт хийгдэж, газар тариалангийн 5 аж ахуй нэгж, худалдаа үйлчилгээний 3 аж ахуй нэгж, нэг малчин хамрагдан зөвлөн туслах үйлчилгээ авлаа.

Хаврын хуурайшилт эхэлсэнтэй холбогдуулан сумын хэмжээнд ойд явуулах үйл ажиллагааг хуулийн хугацаанд нь буюу 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар зогсоож, “Бүх нийтийн цэвэрлэгээ”-ний ажлыг зохион байгуулж нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэн хогны нэгдсэн цэгт хүргэх ажлыг төр төсвийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүдийн оролцоотой хийж гүйцэтгэлээ.

Дэлхийн “Усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн гишүүд болон тус сумын Д.Мягмарын нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Усны зөв хэрэглээ” сэдвээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж ажиллаа.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дугаар А/52 тоот тушаалын дагуу Орхон бүсийн сум дундын ойн анги нь Байгаль орчны хяналтын улсын байцаагч, цаг уурч, байгаль хамгаалагч нартай хамтран Дэлхийн Ойн өдөр, Усны өдрийг тохиолдуулан “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөл, иргэдэд ойн хомсдол, доройтол, ой хээрийн түймэр, ус цаг уурын талаарх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулж, ном сонин, гарын авлага, материал тарааж ажиллаа.

Лэнд менежер программ хангамжинд сумын эзэмшил ашиглалт, өмчлөлийн нэгж талбарын хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтийг, 2016 2017 оны хувийн хэргүүдийг цаасан болон тоон хэлбэрт шилжүүлэх ажлыг хийж, Дархан-уул аймгийн Хөдөө аж ахуйн их сургуулийн Газар зохион байгуулагч инженерийн 4 дүгээр ангийн 1 оюутанг дадлагажигчаар авч ажиллуулан сумын Газрын даамлын ажил байдалтай танилцуулан дадлагажуулан ажиллуулж байна.

Төрийн санд 2018 оны 03 дугаар сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого төлөвлөгөөгөөр 30196.9 төгрөг орохоос гүйцэтгэлээр 6482.3 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 21.4%- тай байна. Туслах үйл ажиллагааны орлого болон үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөгөөр 7100.0 мянган төгрөг орохоос гүйцэтгэл нь 4795.9 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 67.5%-тай байна.

Сумын эрүүл мэндийн төвөөс Бургалтай 2-р баг, Ивэн 1-р багийн айл өрхүүдээр гэрийн эргэлт хийж өндөр настан, жирэмсэн эх, 0-5 насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үзэж зөвлөгөө өгч, нийт 43 хүн хамрагдсан байна.

Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд ЕББДС-иас 14 төрлийн хичээлээр 14 багш, 28 сурагч хамрагдлаа. Мөн сургуулийн эцэг эхийн зөвлөл, номын санчтай хамтран “Сэтгэлийн эгшиг” уран уншлагын тэмцээнийг нийт сурагчдын дунд амжилттай зохион байгуулж шагналт байруудыг шалгарууллаа. Сурагчдын ёс зүйн зөвлөлийн сурагчид “Сургуулийн орчинд бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй байя” аяныг санаачлан хэрэгжүүлж байна.

СӨБ-ын байгууллагаас бүлгийн багш нар хүүхдийн өсөлт хөгжлийн болон шүдний өвчлөлийн судалгааг гаргасан. Мөн багш нарын дунд “Сайн хичээл үйл ажиллагаа”-г зохион байгууллаа.

Баянгол сум:

Малчдын хаваржилтын байдалтай танилцан “Дөлгөөн энэрэл” МЭҮН-тэй хамтран Гонир багийн Цагаанчулуут орчмын малчин өрхүүдээр ажилласан. Энэ сарын 20-ны байдлаар нийт 2976 толгой мал төллөж, төлийн бойжилт 97,7 хувьтай байна. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлгийг 3 багийн 30 орчим малчин, мал бүхий иргэдэд өгсөн.

Дэлхийн усны өдрийг угтаж “Байгальд ээлтэй усны шийдэл-2018” уриан дор зохион байгуулж, ЕБС-ийн сурагчдад “Цэнхэр нүдэн гариг” гар зургийн уралдаан, “Амьдралыг тэтгэгч усыг бие, сэтгэл зүрхээрээ хайрлацгаая” ханын сонингийн уралдааныг явуулж, “Центавр” тэмцээн, “Дахин боловсруулсан усыг аж ахуй ашиглах нь” сэдэвт гарын авлагыг бэлтгэн тараасан. Мөн Бүжинхэн цэцэрлэгийн хүүхдүүдэд “Ус гэж юу вэ?” видео сургалт хийлээ.

Хараа багийн нутагт буусан шар усны үерт автсан айл өрхүүдэд туслах, үерээс хамгаалах далан байгуулах ажилд төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж иргэд хамтран ажиллаж 130 гаруй хүн оролцлоо.

Сумын нутаг дзэвсгэрт золбин нохой, муур устгах ажлыг зохион байгууллаа.

ЭЕШ-ийн бүртгэлд тус сумын 59 сурагч онлайнаар бүртгүүлсэн.

Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн “Art gallery” үзэсгэлэнгийн танхимд сумын ЕБС-ийн Д.Төртүвшин, өөрийн хүүгийн хамт уран хайчилбарын үзэсгэлэнгээ гаргалаа. ЕБС-ийн 12-р ангийн 48 сурагчид “Хуулиа мөрдье, сэрэмжлье, нэгдье” аяны хүрээнд хулгайн гэмт хэргээс сэргийлэх, архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэж буй зөрчилтэй тэмцэх, хэрэг зөрчлийн талаар мэдээлэх талаар яриа таниулга хийж, 65 суралцагчид зөрчлийн тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар мэдээлэл хийлээ.

Мөн сургуулийн зүгээс “Хайраар дүүрэн хүүхэд нас” аяны хүрээнд “Хүүхдээ сонсох өдөр”-ийг зохион байгуулж, хүүхдийн санал хүсэлтийг сонсож, зарим асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

Ерөө сум:

Сумын Засаг даргын Тамгын газраас санаачлан зохион байгуулдаг “Хүлээж биш хүрч үйлчилье” сэдэвт уламжлалт арга хэмжээг “Тавин” багийн нутагт 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээг Тавин багийн нутаг Шаазгайт, Зүүн, Баруун сэнстэй зэрэг 3 хэсэг газарт иргэдийг цуглуулан зохион байгуулж, нийт 25 өрхийн 70 орчим иргэнд төрийн үйлчилгээг хүргэж ажиллалаа.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2018-03-05-ний өдөр сумын хэрэглэгчийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн 5 гишүүнд танилцуулж, 16 иргэнд сургалт, хэлэцүүлэгийг хийлээ.

Жил бүрийн 03-р сарын 21, 22-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлдэг Дэлхийн ойн өдөр, Олон улсын усны өдрийг тохиолдуулан гарын авлага, сурталчилгааг 138 иргэнд тарааж, ЕБС-ийн 87 сурагчдад тэмдэглэлт өдрийг сурталчлан АХА тэмцээн зохион байгууллаа.

Иргэний гаргасан гомдлын дагуу худалдаа үйлчилгээний газарт сумын “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөл”-өөс иргэдэд НӨАТ-ын баримт олгож байгаа эсэх, бараа бүтээгдэхүүний үнэ нэг бүрчлэн бичигдсэн эсэх, бараа бүтээгдэхүүний хадгалах хугацаа болон чанар аюулгүй байдалд хийх хяналт шалгалтыг 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал дээр зөвлөгөө, үүрэг даалгавар өгч ажилласан бөгөөд хадгалах хугацаа нь дууссан, чанар байдлаа алдсан 8 нэр төрлийн 94 ширхэг 143800 төгрөгний үнэ бүхий хүнсний бараа бүтээгдэхүүнийг акт үйлдэн хураан авч устгалд орууллаа.

“Болзошгүй аюул, галын аюул газар хөдлөлтөөс өөрийгөө болон найз нөхдөө хэрхэн аврах вэ?” сургалтыг цэцэрлэгийн багш ажилчид, хүүхдүүдийн дунд зохион

байгуулж, 3 удаагийн давтамжтайгаар дуут дохиог ажиллууллаа. Уг сургалтанд цэцэрлэгийн 161 хүүхэд, 19 багш ажилчид хамрагдлаа.

Жавхлант сүм:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Иргэдээ сонсоё” уулзалт ярилцлагыг зохион байгууллаа. Уулзалт ярилцлагад сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын Тэргүүлэгчид, төлөөлөгчид, аймгийн ИТХ-ын төлөөлөгч сумын Засаг дарга Ж.Отгондалай нар оролцлоо. Уулзалтаар сумын ИТХ-аас 2017 онд хийсэн ажлын тайлан, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2017 оны ажлын тайланг хэлэлцүүлж, иргэдээс сумын төр төсвийн байгууллагуудын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч санал хүсэлтийг сонслоо.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол Улс дахь терроризмын нөхцөл байдал, Байгаль орчны болон Татварын ерөнхий хуулийн хэлэлцүүлэг, сургалтуудыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 120 төрийн албан хаагч, иргэд, сурагчид хамрагдлаа .

Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд учирсан хохирлыг тооцох аргачлал”-ын төслийн хэлэлцүүлэгт тус сумын 3 малчин, 3 тариаланчинг хамруулсан.

Тайлант сард иргэний 22 бүртгэл хийгдсэнээс төрөлт 3, нас баралт 2, гэрлэлт 1, иргэний үнэмлэхний бүртгэл 6, шилжин ирсэн 1, шилжин явсан 5, иргэний үнэмлэх хэвлэгдэн ирж үнэмлэхээ авсан 4 бүртгэгдлээ.

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас 3-р сард 310 тэтгэвэр авагч байснаас өндөр настан 223 тэтгэвэр авагчид 66940,0 мянган төгрөг тахир дутуу 71 тэтгэвэр авагчид 19327 мянган төгрөгийн тэтгэвэр тэжээгчээ алдсан 13 тэтгэвэр авагчид 3420,0 төгрөгийн тэтгэвэр цэргийн тэтгэвэр авагч 3 1503,4 мянган төгрөгийн тэтгэвэр нийт 310 тэтгэвэр авагчид 66940,0 төгрөгийн тэтгэврийг, ажилгүйдлийн даатгалын сангаас 2 даатгуулагчид 169000 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг, Тэтгэмжийн даатгалын сангаас 2 даатгуулагчид 1330910 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмжийг, 1 даатгуулагчид 77943 мянган төгрөгийн ХЧТА-ны тэтгэмжийг, оршуулгын тэтгэмжинд 3 даатгуулагчид 3000000 төгрөгийг тус тус олгосон.

Соёлын төвөөс эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж “Ижийдээ захидал бичээрэй” захидлын уралдаан, Зэвсэгт хүчний 97–н жил өдөр, Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан “Эрчүүдээ дуулья” үдшийн цэнгүүн, “Шагайн харваа” тэмцээн, Нийтийн номын сангаас “Миний сайхан аав” эссэ бичлэгийн уралдааныг тус тус зохион байгууллаа.

Зүүнбүрэн сүм:

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлж, цэвэр сайхан орчинд хүмүүжүүлцгээе” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж 438 иргэнийг хамрууллаа.

Монгол цэргийн өдрийг тохиолдуулан "Нэг баг-Нэг агт" аяныг зохион байгуулж, Хил хамгаалах 0243 дугаар ангид 3 агт бэлэглэж, хил хамгаалах ангиас аянд идэвхтэй оролцсон иргэн, багийн Засаг дарга нарыг шагнаж урамшууллаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнд зохион байгуулагдсан “Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, малчдад учирсан хохирлыг тооцох аргачлал” хэлэлцүүлэгт “Шимт бүрэн” ХХК, “Тэгшхан” ХХК-иудын төлөөлөл, сумын Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нар оролцож санал бодлоо уламжиллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын эцэг эхчүүдийн дунд болон бага ангийн заах аргын нэгдлээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эцэг эхийн хишиг өдөр”, “Багш –Эцэг эх” арга хэмжээнүүдийг зохион байгуулж, “Тогтвортой хөгжлийн боловсрол”, “Эко сургуулийн орчны үнэлгээ” сэдэвт сургалтуудыг явуулан ахлах ангийн сурагчдын 16 эцэг эх багш болж 51 цагийн хичээлийг заалаа. Дээрх арга хэмжээнүүдэд 168 эцэг эхийг хамрууллаа.

Мандал сум:

Мандал сумын “Удирдах ажилтны зөвлөгөөн-2018” зөвлөгөөнийг зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн 41 аж ахуй нэгж, байгууллагын дарга эрхлэгч нар, багийн Засаг дарга нар оролцож сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилт, эдийн засаг нийгмийн 2017 оны танилцуулга, хүн амын эрүүл мэндийн болон гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд аж ахуй нэгж байгууллагын оролцооны талаар мэдээлэл хийлээ.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг танилцуулах, цаг үеийн мэдээллээр иргэдийн хангах, иргэдийг санал хүсэлтийг сонсох, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “Тариаланчдын зөвлөгөөн”, “Төвийн 6 багийн иргэдийн уулзалт”, “Хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөгөөн”, “Худалдаа эрхлэгчдийн уулзалт зөвлөгөөн”, “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг Мандал бүсэд хэрэгжүүлэх нь” зөвлөгөөн, “Ногоочдын зөвлөгөөн”, “Малчдын зөвлөгөөн”-ийг тус тус зохион байгуулж, дээрх арга хэмжээнүүдэд 1117 иргэд иргэдийг хамрууллаа.

Аймгийн “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн албан хаагчид болон Хэрх, Түнхэл тосгоны Захирагчийн албаны мэргэжилтнүүдийг хамруулан Удирдлагын академийн багш, доктор Т.Алтанцэцэгийг урьж Төрийн албан хаагчийн имиж бүрдүүлэлт, Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, Өөрийгөө таниж удирдахуй зэрэг сэдвээр “Суралцагч байгууллага-Төрийн албан хаагчийн манлайлал” сургалтыг зохион байгууллаа.

Хүүхэд багачуудын авьяас чадварыг дэмжин хөгжүүлэх замаар нийгэмшүүлэх, дуулах ур чадвар олгон тэдний урлагийн гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлэх зорилгоор “Би эстрадын дуучин-2018” уралдааныг аймгийн Гэр бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газартай хамтран 03 дугаар сарын 19-ний өдөр “Мөнгөн Хараа” Дуу Бүжгийн Чуулгад зохион байгууллаа.

Орхон сум:

2018 оны 03 дугаар сарын 07-ны өдөр сум орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүргэх, сумын хөгжилд эмэгтэйчүүдийн идэвхи оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор сумын эмэгтэйчүүдийн III чуулга уулзалтыг “Хөгжлийн төлөө бид хамтдаа” уриатайгаар зохион байгуулж 170 гаруй эмэгтэйчүүд уулзалтын үйл ажиллагаанд оролцлоо.

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Тус ажиллагаагаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг аюулгүй цэгт нүүлгэн шилжүүлэх, иргэдийг объектоос гаргах, гамшигт өртсөн хүүхдүүдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зэрэг ажиллагаануудыг сумын ЭМТ, мэргэжлийн ангийн аврагчид гүйцэтгэж нийт 120 гаруй иргэнийг хамруулан “Аюулгүйн цэгт шилжин байрших”, “Нүүлгэн шилжүүлэх” тактикийн дадлага сургуулийн үйл ажиллагаа хийгдлээ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Эко-сургууль”-ийн 3 үе шат бүхий сургалтыг 02, 05, 08 дугаар саруудад зохион байгуулахаар төлөвлөсний дагуу Мандал суманд зохион байгуулагдлаа. 1-р шатны сургалтанд тус сумын

ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, биологийн багш, эмч, сурагчийн төлөөллөөс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг хамрагдсан.

Сант:

Сумын хэмжээнд 03-р сарын 20-ны өдрийн байдлаар гүү 41, үнээ 123, эм хонь 4680, эм ямаа 2100 бүгд 6944 эх мал төллөн төлийн хорогдолгүй бойжиж байна. Том малын хорогдол адуу 2, үхэр 34, хонь 31, ямаа 20 бүгд 87 бүртгэгдсэн дүнтэй байна.

Хаваржилтын нөхцөл байдалтай холбогдуулан сумын аюулгүйн нөөцөөс 1458 боодол өвс, аймгийн аюулгүй нөөцөөс 800 боодол өвсийг хүндрэлтэй байгаа малчин өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр нийлүүлснээс гадна УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатын саанаачилгаар 20 тонн хивэг, 800 боодол өвсийг өвс тэжээлийн дутагдалтай байгаа өрхөд хуваарилан тараасан байна.

Сумын Ивэн, Хушаат багийн малчид болон мал бүхий иргэдэд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмжийг хүргэж, 8479 малд үзлэг тандалт хийсэн.

Хаврын тариалалтын ажил эхэлж арилжааны банкууд тариалалтын зээл олгож байгаатай холбогдуулан төмс, хүнсний ногоо тариалах 25 иргэнд тариалалтын тодорхойлолт олгон талбайн түүх хөтлөх талаар мэлээлэл өгч 12 иргэнийг төмс, хүнсний ногооны талбайн түүхийн дэвтрээр хангасан.

Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлал” сэдэвт хэлэлцүүлэгт сумаас малчид, ногоочдын төлөөлөл 4 иргэнийг оролцуулсан.

3 дугаар сарын 19-ний өдөр аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна орчны цэвэрлэгээний ажил хийгдэж 25м.куб хог цэвэрлэж, тээвэрлэн хогийн хаясан.

Дэлхийн ойн өдөр, Олон Улсын усны өдрийг угтаж сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ойн нөхөрлөлийн удирдах гишүүдтэй ойн доройтол, хууль бус мод бэлтгэлийн талаар санал солилцож санамж, мэдээлэл хүргэсэн ба сумын усан сангийн алдагдлыг багасгах бууруулах асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Сумын онцгой штабын удирдлагын шийдвэрээр байгалийн аюултай үзэгдэл /цасан шуурга/-д өртсөн 18 иргэнийг аврах ажиллагаанд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын гал унтраах аврах 61-р анги, сумын ЗДТГ-ын албан хаагч нар оролцож аврах ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Сумын ГХУСАЗСЗ-өөс ЕБС-ийн ахлах ангийн 38 сурагчдад уулзалт ярилцлага зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй ажил, цаашдын хамтын ажиллагаа, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг сурталчилж ажилласан байна. Мөн сумын уяачдад хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос ирүүлсэн 1/05 тоот зөвлөмжийн дагуу мэдээлэл хүргэж ажилласан байна.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдрөөр сумын хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлөөс “Хэрэглэгчээ дээдлэе” уриан дор нээлттэй өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж 32 иргэнд мэдээлэл зөвлөмж хүргэн санал асуулга авсан байна. Мөн ЕБС-ийн 9-12-р ангийн 38 сурагчдад “Хүүхэд бүрийг хэрэглээний соёлд суралцуулья” сэдвээр мэдээлэл хүргэж мэдлэг бататгах АХА тэмцээнийг зохион явуулсан байна.

2018.03.06-ны өдөр сумын ЗДТГ-аас “Төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт” арга хэмжээг зохион байгуулж нийт 76 малчин эмэгтэйчүүд оролцсон байна. Чуулга уулзалтаар мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээлэл болон хүүхдийн эрхийн хамгаалал, гэр бүлийн боловсролын талаар асуудал хөндөж “Хүүхдээ хэрхэн зөв хүмүүжүүлэх вэ” сэдвээр илтгэл мэдээлэл хүргэсэн байна. Төлчин эмэгтэйчүүд маань ЕБС-ийн дотуур байранд амьдардаг амьжиргааны түвшин доогуур өрхийн 3 сурагчид хичээлийн хэрэгсэл, хувцас, өндөр настан 1 иргэнд хүнсний болон мөнгөн хэлбэрээр тусламж дэмжлэг үзүүлсэн байна.

Нийтийн бүжгийг иргэдэд сурталчилах, байгууллага хамт олон, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Соёлын төвөөс “Бүжигчин хамт олон” байгууллага сурталчилах аяныг зохион байгуулж 250 гаруй иргэд оролцсон байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан сумын Эмэгтэйчүүдийн холбооноос “Эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-ыг зохион байгуулж ажил үйлс, амжилт бүтээлээрээ бусдыгаа манлайлсан эмэгтэйчүүдийг шагнаж урамшуулсан байна. Энэхүү арга хэмжээнд 230 гаруй эмэгтэйчүүд хуран чуулж санал бодлоо солилцсон байна. Мөн Соёлын төвөөс “Эмээдээ захидал бичээрэй” захидлын уралдаан, “Ээждээ өгөх миний бэлэг” наамал бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулж, 64 сурагч хамрагдсан байна.

Хушаат сум:

Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын постыг ажиллуулж, 1-р багийн малчин С-ийнд үзлэг тандалт хийж гахайн байр, өвөлжөө, хашаанд ариутгал халдваргүйжүүлэлт хийснээс гадна Артойлбо, 2-р бригадын малд тандалт явууллаа. Мөн захирамжийн дагуу мал амьтан түүнээс гаралтай эд бүтээгдэхүүн, өвсийг 7 хоногийн хугацаатай оруулах, гаргах шилжилт хөдөлгөөнийг бүрэн хязгаарласан.

“Golden Map” ХХК тус суманд энэ сарын 17, 18-нд ажиллаж, сумын иргэдэд кадастрын зураг хийж үйлчилсэн ба 57 хашааны газар, 5 байшингийн газарт кадастрын зураглал хийлгэсэн байна.

Энэ сард улсын бүртгэлийн үйлчилгээгээр төрсний бүртгэл 7, эцэг тогтоосны бүртгэл 4, нас барсны бүртгэл 1, иргэний үнэмлэхийн бүртгэл 13 бүртгэл бүртгэгдэн шилжин явсан 5, шилжин ирсэн 4 иргэнийг бүртгэсэн.

Нийгмийн даатгал болон ЭМД-ын тухай хуулиудыг 482 сурталчилж, нийгмийн даатгалд болон ЭМД-д малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэдийг сайн дурын даатгалд хамрагдагдах талаар таниулга хийн ажиллаж 158 иргэнд гарын авлагыг тараан ажилласан.

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг төрийн хошой шагналт, их зохиолч Д.Сэнгээгийн нэрэмжит “Уншихын олимпиад”-ыг 3-р сарын 14-16- ны өдрүүдэд “Утгын чимэг, уран сэтгэмж” нэртэйгээр 2 төрлөөр байгуулснаас гадна эцэг эхийн дунд илтгэлийн уралдааныг явууллаа.

Төрөлжсөн хичээлийн олимпиадын 2-ын даваанд 12 төрлийн хичээлээр 25 сурагч, 11 багш оролцлоо.

Сургуулийн 9,10,11,12 дугаар ангийн сурагчдад “Охидын гоо сайханд өгөх зөвөлгөө”, “Архи тамхины хор уршиг” сэдвээр, 1-5 дугаар ангийн сурагчдад “Гарын ариун цэвэр” сэдвээр тус тус сургалт хийлээ.

Цэцэрлэгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөний дагуу сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Тайлант сард жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Дээлтэй Монгол-2018” өдөрлөгийг бүлгүүдийн дунд зохиож, Олон Улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан 4 бүлгийн хүүхдүүд ээжүүдээ баярлуулан өөрсдийн хийсэн “Миний ээж хөөрхөн” бүтээлээр гэнэтийн бэлэг болгож, бяцхан урлагийн тоглолт, “Хүчит бөхийн барилдаан”-ыг зохион байгууллаа.

Сумын соёлын тэмцээн уралдаан 2, урлагийн тоглолт 1, үдшийн цэнгүүн 1 зохион байгуулагдаж, орон нутаг судлах танхимаар нийт 48 иргэн үйлчлүүлж, иргэдийн дунд “Угийн бичиг” хөтлөх талаар сургалт хийсэн.

Хүдэр сум:

Тайлант сард Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж сумын Засаг даргын үйл ажиллагааны тайланг иргэдэд мэдээлэх, төрийн албан хаагчдын уулзалт зөвөлгөөнийг зохион байгуулах, хог цэвэрлэгээ зохион байгуулах, Шар усны үерээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Эрх зүйн сургалт сурталчилгааг Зөрчлийн тухай хууль, Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, МУИГӨТухай хуулийн хэрэгжилт, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн болон Нийгмийн даатгалын тухай хууль болон Хөдөлмөр эрхлэлт ба төсөл хөтөлбөр зэрэг сэдвүүдээр сургалт сурталчилгааг хүргэж сургалтанд 89 иргэн 5 аж ахуйн нэгж хамрагдаж, 250 иргэнд сурталчилгааны материал тараасан.

2017 онд Улсын хэмжээнд гарсан шүлхий өвчин, өвчний талаар гарч болзошгүй урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг орон, нутгийнхаа нийт 94 малчин өрх буюу 400 мал бүхий иргэдэд 2-3 удаагийн сургалтанд хамрагдсан 84 иргэнд өвчний талаарх сэрэмжүүлэг мэдээлэл гарын авлагыг өгсөн. Шүлхий өвчний талаархи урьдчилан сэргийлэх үзлэг тандалтуудыг 64 малчин өрхийн үхэр сүрэгт хийсэн. Мал төллөлтийн байдлын мэдээгээр сумын хэмжээнд тугал- 675, Хурга-930, Ишиг-560 төл мал төллөн бойжиж байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэнд өмчлүүлэх газрын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ суурьшлын бүс тогтоох ажлын хэсэг байгуулагдаж, нийт 600 иргэнээс саналыг авч нэгтгэн сумын ИТХ-д оруулаад байна. ХАА-н бэлчээр болон хадлангийн зориулалттай талбай дээр модны мэргэжлийн эрх бүхий байгууллагууд зөвшөөрөлгүйгээр ойжуулалт хийж тарьц суулгах болсонтой холбоотойгоор ойн ангитай хамтран мод бэлтгэх эрх авсан аж ахуйн нэгжүүдийн мод бэлтгэлийн талбай тусгаарлалтанд явж, талбай тусгаарлуулсан газартаа ойжуулалтаа хийж байх талаар зөвлөгөө өгч ажилласан.

БОАЖ-ын салбарын хэмжээнд орон даяар зохион байгуулагдсан нээлттэй өдөрлөгийг 3 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд хийж, Ойн хээрийн түймэр, Ойн тухай хууль холбогдох дүрэм журам, Зөрчлийн тухай хууль, Амьтны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хүдэр сумын Ойн сан, мод бэлтгэлийн талаар мэдээлэл өгч, гарын авлага, брошур тарааж өдөрлөгийг 2 хоногийн хугацаанд зохион байгууллаа.

Сургууль, цэцэрлэгийн болон эрүүл мэндийн төв, соёлын төвүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулж, нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон.

Түшиг сум:

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 5 дугаар хуралдаанаар сумын “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлсэн.

2018 оны 03 дугаар сарын 21нд Жаргалмандах, Арнуга багийн Иргэдийн Нийтийн Хурлыг зохион байгуулж, багийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлж, 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх саналыг авлаа.

Сумын төрийн захиргааны 15 албан хаагчийн үйл ажиллагааны 1-р улирлын тайлан мэдээллийг хэлэлцэж, дүгнэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” сумын Засаг даргын захирамж гарч, цэцэрлэгийн 5 бүлгийн 65 хүүхэд, Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн 115 сурагчид хамрагдлаа.

Сумын Засаг даргын 2018 оны А/28 тоот захирамжаар 03 дугаар сарын 20-оос 06 дугаар сарын 10 хүртэл ой, хээрт аялал зугаалга хийх, ойн дагалт баялаг ашиглах, ойд ямар нэгэн үйл ажиллагаа явуулахыг түр хугацаагаар зогсоож, ой хээрийн түймрээс урьчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлаж, хуурайшилтын үед ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүрийг томиллоо.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс эргүүл, жижүүрийг томилж, суманд туувраар мал оруулах гэж байсан мэдээллийн дагуу 1 иргэний малыг албадан гаргалаа.

Сумын хэмжээнд: шүү 82, үнээ 416, эм хонь 4894, эм ямаа 2960 төллөж, мал төллөлт 30,1%-тай байна.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Соёлын төвтэй хамтран “Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдаан зохион байгуулж, нийт 25 иргэн оролцлоо. Мөн “Дархан бэр” тодруулах арга хэмжээг зохион байгуулж, 3 хүү дараалан төрүүлж, үр хүүхдээ Монгол эмэгтэйн хатан ухаанаар хүмүүжүүлсэн нийт 43 эмэгтэйг тодруулж хүндэтгэл үзүүллээ.

Зэвсэгт хүчний 93 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг угтан “Би чадна”, “Караоке” тэмцээн зохион байгуулж, нийт 5 багийн 25 иргэн оролцлоо.

Цагааннуур сум:

Сумын хэмжээнд “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль”-ийг 3-р сарын 20-ны өдрийн 16:00 цагт эхлүүлэн зохион байгууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын Олон улсын өдөр, Дэлхийн усны өдөрт зориулан 3-р сарын 21-ний өдөр “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ” зохион байгуулж, сумын 12 аж ахуйн нэгж байгууллага, 5 нөхөрлөл, 130 гаруй иргэн, ЕБС-ийн сурагчид оролцсон. Өдөрлөгийн үеэр аймгийн УЦУОШТ-ийн мэргэжилтэн, аймгийн БОАЖГ-ын хуулийн зөвлөх нар мэдээлэл хийж, “Ой ба Ус” сэдэвт ханын сонингийн уралдаан, АХА тэмцээнийг ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд явуулж дүгнэлээ.

Мөн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан энэ сарын 16-ны өдөр ЕБС-ийн сурагчдад сургалт хийсэн.

Аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг энэ сарын 3-4-ний өдрүүдэд сумын Спорт цогцолборт амжилттай зохион байгууллаа. Тэмцээнийг УБТЗ-ын МБҮйлдвэр ивээн тэтгэж, нийт 15 сургуулийн эрэгтэй 18, эмэгтэй 11 баг, 348 тамирчид өрсөлдсөн.

Сумын татварын орлого 1-р улирлын байдлаар 20341,0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 3-р сарын 23-ны байдлаар 21619,4 мянган төгрөгийг төвлөрүүлж, 106,3 хувийн гүйцэтгэлтэй байна. Сумын хэмжээнд нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгосон.

Ииргэний бүртгэлийн үйлчилгээг зохих заавар, журмын дагуу үзүүлж, шинээр төрсөн 14, гэрлэлтийн 6, эцэг тогтоолт 1, гэрлэлт цуцлалт 1, нас баралт 3, аймаг хот дотор болон аймаг хотруу бүрмөсөн шилжин явсан 17, шилжин ирсэн 21 иргэний бүртгэлийг хийж, иргэний шинэчилсэн бүртгэлд 28 иргэн хамрагдаж, 25 иргэнд цахим үнхэмлэх олгож үйлчиллээ.

Шаамар сум:

Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу сумын Засаг даргын 2018 оны А/19 тоот захирамжаар Дулаанхаан тосгоны “Ахмадын өргөө барих” ажлын тендер сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг байгуулж, тендерийн баримт бичгийн бүрдлийн шаардлагыг хангасан бичиг баримтыг бүрдүүлэн олон нийтэд мэдээлэх ажлыг хуулийн хугацаанд www.tender.gov.mn цахим хуудаст тендерийн урилгыг байршууллаа.

Сумын 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Охиндий 2 дугаар багт баригдах Хүүхдийн тоглоомын талбайн ажлын гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын “Титан Оргил” ХХК шалгарсан бөгөөд хуулийн хугацаанд ажил гүйцэтгэх гэрээг байгуулахаар захиалагчид хүсэлтээ хүргүүллээ.

Монгол Улсын Нийтийн сонсголын тухай хуулийг орон нутаг сурталчлан таниулах, хэрэгжүүлж хэвшүүлэх, иргэдийн үзэл бодол, байр суурийг шийдвэр гаргагчдад хүргэх нийтийн сонсголын арга хэмжээг 2018 оны 02 дугаар сарын 26-ний 14:00 цагт сумын Соёлын төвийн Урлагийн танхимд зохион байгууллаа. Сонсголд нийт 144 иргэн оролцож, Нийтийн сонсголын тухай хуулийн ач холбогдол, эрх зүйн зохицуулалт болон Шаамар суманд 2013-2017 онуудад Орон нутгийн хөгжлийн

сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын талаарх мэдээлэл, 2018 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын сангаар хийгдэх ажлын саналыг хяналтын сонсголоор хэлэлцүүлж, сэдвийн хүрээнд иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлж ажиллалаа.

“Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” аймгийн дэд хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор төрийн албан хаагчдын мэргэшлийн ур чадварыг эзэмшүүлэх, манлайллын түвшинг нэмэгдүүлэх, төрийн удирдах албан тушаалтнуудын соёлтой, ёс зүйт удирдлагыг дээшлүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, байгууллагад чиглүүлэх сургалтыг тогтмолжуулж, шинээр ажилд орох ажилтнуудад шаардлагатай стандартын мэдлэг чадварыг олгох зорилгоор 28 зорилт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг албан хаагчдад үүрэг болголоо.

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчний байгууллага үүсэн байгуулагдсаны 97 жилийн ой, **“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”**-ийг тохиолдуулан сумын цэргийн насны болон бэлтгэл зэрэгтэн залуучууд, эрчүүдийн бие бялдарыг чийрэгжүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор **“ЭРЧҮҮДЭЭ УРАГШАА”** спортын олон төрлийн арга хэмжээг явуулж, сумын залуучуудын идэвхи санаачлагыг өрнүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, батлан хамгаалах бодлого шийдвэрийг сум орон нутагт сурталчлах арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

“Хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын өдөр”-ийг тохиолдуулан ЕББДС-ын ахлах ангийн сурагчдын дунд “Хүүхэд бүрийг хэрэглээний соёлд суралцуулъя” сэдэвт сургалтын зохион байгууллаа.

Дэлхийн Усны өдрийг тохиолдуулан орон нутагт усыг зөв зохистой ашиглах, цэвэр усны эх үүсвэрийг хамгаалах, зохистой хэрэглээг нэмэгдүүлэх “Ус ба байгаль” сэдэвт сураглтыг сумын Ерөнхий боловсролын сургууль болон МСҮТ-ийн оюутан, сурагчдад явуулж 90 гаруй оюутан сурагчид хамрагдлаа. Сургалтаар ус байгальд орших байдал, усны нөөц, ус ашиглалт, усны бохирдол, усны зохистой хэрэглээ зэрэг өнөөгийн нийгэмд тулгамдаж буй сэдвийг хөндсөн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, төр засгийн бодлого шийдвэрийг орон нутагт хэрхэн хэрэгжүүлэх, мөн байгаль эх дэлхийгээ хайрлан усыг зүй зохистой хэрэглэхийг гэр бүл, хамт олон, найз нөхөд уриалж, хэрэгжүүлж ажиллахыг багш, оюутан сурагчдад уламжиллаа. Оюутан сурагчдын мэдлэгийг баталгаажуулах асуулт хариултын “АХА” тэмцээн зохион явуулж амжилттай оролцсон оюутан сурагчдыг урамшууллаа.

МУ-ын Засгийн газрын тогтоолын дагуу “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дохиогоор ажиллах” журмын дагуу газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургалтыг 2018.03.21-ны өдрийн 16.00 цагт зохион байгуулж боловсролын байгууллагын 412 хүүхэд багачууд, оюутан сурагчид, мөн 7 байгууллагын 133 эмч, багш, ажилтан, албан хаагчдыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд хамрагдаж газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг орон нутагт нэгдсэн зохион байгуулалттай явууллаа.

Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газраас аймгийн цэргийн штабын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлын хүрээнд сумын батлан хамгаалах товчоо, ЗДТГ-т бэлэн хадгалагдаж буй сумын Засаг даргын “Дайчилгааны удирдах төлөвлөгөө”, маш нууцын зэрэглэлтэй “Харанга” битүүмжилсэн дугтуй бүхий хавтас, аймгийн Засаг даргын “Нууц түлхүүрийг ашиглах заавар” бүхий албан бичиг бүхий удирдамж, орон нутгийн цэргийн орон тоо, дайчилгааны далгавар болон бэлтгэл офицер, ахлагч нарын тооцооны хуудас, 1-р зэргийн бэлтгэл үүрэгтний тооцооны хуудас болон оногдуулан данслагдсан картын бүртгэлийг зааварчилгааны дагуу бэлтгэн аймгийн Цэргийн штабт хүргүүллээ.

Аймгийн МХГ-ын даргын удирдамжийн дагуу Шаамар суманд төлөвлөгөөт болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хяналт, шалгалтууд энэ сарын 15-16 ны өдрүүдэд явагдаж нийт 10 албан байгууллага, 2 эмийн эргэлтийн сан, 11 аж ахуй нэгж, 2 халаалтын төв, 3 мал эмнэлэг үржлийн нэгж, 3 иргэн болон 2 гүний худаг түрээслэгч зэрэг 30 гаруй байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд 48 хууль тогтоомж

тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийн байдалд шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, урьдчилан сэргийлэх шалгалт, тандалт судалгаа, хяналт шинжилгээг хийж гарсан зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, зарим зөрчлийг шийтгэврийн хуудсаар гүйцэтгүүлэхээр хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажиллалаа.

Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчийн баримт материалыг дугаарлан цахим болон цаасан хувийн хэргийн бүрдэлтэй болж, хугацаа хэтэрсэн 8 зээлдэгчийн материалыг аймгийн сум дундын Шүүхийн эвлэрүүлэн зуучлах албанд өргөдөл гаргаж хүлээлгэн өгч дахин 3 иргэний материалыг хүлээлгэн өгөхөөр холбогдох материалыг бэлтгэсэн. Сум хөгжүүлэх сангийн 2013, 2014, 2015 онуудын зээлдэгч нарт зээл төлөх тухай албан мэдэгдэлийг хүлээлгэн өгч гарын үсгээр баталгаажуулсан бөгөөг 03 сарын байдлаар зээлдэгчид 11,0 сая төгрөгийн зээлийг барагдуулсан байна.

МУ-ын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Дархан-Уул аймгийн УГТЭШХ-д зохион байгуулсан Тариалангийн хуулийг хэрэгжүүлэх, тариалангийн талбайд мал орсоны улмаас учирсан хохирлыг тогтоох аргачлалын талаарх хэлэлцүүлэгт зохих төлөөллийг оролцуулж, орон нутагт хэрэгжихэд хүндрэлтэй асуудлуудыг хуульд нэмэлт өөрчлөлтөөр зохицуулалтыг шийдвэрлэж эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналаа хүргүүлээ.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй “Аюулгүй интернетийн өдөр”-ийг тохиолдуулан хүүхэд залуучууд, өсвөр үеийнхний цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах, интернэт мэдээллийн технологийн сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, зөв зохистой хэрэглээг бий болгох зорилгоор ЕББДС-ын дунд ангийн сурагчдын дунд “Аюулгүй интернет”, “Цахим тоглоомын хор хөнөөл” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Нийт 70 гаруй сурагчид хамрагдлаа.

"Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох үйл ажиллагаанд хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ"-ний дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 17 өрхийн 117 гишүүнд 2018 оны 3 дугаар сарын талон болох 171 ширхэг үнэт цаас бүхий 1,380 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох "Бүтээл сан" ХХК-ийн "Шонхлой" хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.

2018 оны 3 дугаар сарын байдлаар Шаамар сумын 1, 2 дугаар багийн хэмжээнд шинээр төрсөн эрэгтэй 1, эмэгтэй 1 хүүхэд төрж, нийт 2 хүүхэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгосон. Гэрлэлтээ батлуулах хүсэлт гаргасан 1 иргэний бүртгэн гэрчилгээ олгож, нас барсан 3 иргэний нас барсаны бүртгэлийг хийж гэрчилгээг тус тус олгосон. 2018 оны 3 дугаар сарын байдлаар бусад аймаг хотруу шилжин явсан 4 иргэн, бусад аймаг, сумаас 3 иргэн өөрийн хүсэлтийн дагуу шилжин ирсэн.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Ө.СУВДАА